



## ҮНДЭСНИЙ СТАНДАРТЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТҮВШИН ТОГТООХ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ТАЛААР

Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд УИХ-ын 2017 оны 87 дугаар тогтоолоор "...хүчин төгөлдөр үйлчилж байгаа үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг зохион байгуулах"-аар 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Ерөнхий сайдын 97 дугаар захирамжаар Шадар сайдын ахалсан ажлын хэсэг байгуулж, холбогдох удирдамжийг баталсан.

Энэхүү ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 146 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын салбар комисс байгуулагдан, Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/182 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний стандартын улсын үзлэгийн арга зүйн зааврын дагуу ажиллаж байна

Зам, тээврийн салбарын комисс нь дэд комиссоос бүрдэж байгаа бөгөөд тухайн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Үндэсний стандартын баримт бичгийг хянан үзэж, шинжлэх ухаан, техникийн түвшинг үнэлж, дүгнэлт гаргахаар ажиллаж байна.

Энэхүү ажил нь Монгол Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа чухал ажил тул салбар бүр батлагдсан маягтын дагуу мөрдөж буй стандартуудаа иж бүрнээр нь ба хэсэгчлэн зүйл заалтаар нь шаардлага хангаж буй эсэхийг үнэлж, өөрчлөх, шинэчлэх, хүчингүй болгох болон заавал мөрдөх ба сонгон хэрэглэх зэрэг эрх зүйн хэм хэмжээг тогтоох юм.

Стандартчилал, хэмжил зүйн газраас салбар тус бүрийн стандартыг pdf файлаар ирүүлсэн тул жагсаалттай танилцан, та бүхний албан хэрэгцээнд ашиглагддаг нэмж авах шаардлагатай салбар дундын стандартуудын нэр, кодыг яаралтай ирүүлэх шаардлагатай байна.

ТА бүхэн БТГ-ын СНХэлтсийн 62263182 дугаар утсаар холбогдож аливаа асуулт, тодруулга, нэмэлт мэдээлэл авна уу.

ЗТХЯ БТГ СНХЭЛТЭС  
2018.08.28

ҮНДЭСНИЙ СТАНДАРТЫН ШИНЖЛЭХ УХААН,  
ТЕХНОЛОГИЙН ТҮВШИН ТОГТООХ УЛСЫН  
ҮЗЛЭГИЙН ҮЕ ШАТ

